

**Төрийн албан хаагчийн Сургалт хөтөлбөрийг
2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт**

2018.12.14.

Чойр хот

д/д	Тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ	Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт, тоо хэмжээ, хугацаа	Биелэлт	Хувь
Засгийн газраас баталсан нэгдсэн төлөвлөгөө болон бусад яам агентлагуудаас зохион байгуулах сургалтуудад албан хаагчдыг хамруулах;					
1	Засгийн газраас баталсан нэгдсэн төлөвлөгөө болон бусад яам агентлагуудаас зохион байгуулах сургалтуудад албан хаагчдыг хамруулах;	- Холбогдох албан хаагчдыг сургалтанд хамруулсан байна.	- Албан хаагчдын мэдлэг, чадвар дээшилсэн байна. - 2018 он, сургалтын тоогоор,	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон бусад яам агентлагуудаас зохион байгуулах сургалтуудад албан хаагчдыг чиглэл чиглэлийн дагуу бүрэн хамруулж байна. 2018 оны байдлаар давхардсан тоогоор нийт 151 албан хаагчийг албан томилолтоор сургалт, уулзалт, зөвлөгөөнд хамруулсан байна.	100
2	Засгийн газраас болон холбогдох яам, тамгын газраас зохион байгуулж буй уулзалт, зөвлөгөөнд холбогдох албан хаагчдыг хамруулах	- Холбогдох албан хаагчдыг сургалтанд хамруулсан байна.	- Албан хаагчдын мэдлэг, чадвар дээшилсэн байна. - 2018 он, сургалтын тоогоор,		
3	Аймаг, орон нутагт зохион байгуулж буй нэгдсэн сургалт, зөвлөгөөнд ажилтан, албан хаагчдыг оролцуулах	- 2-оос доошгүй сургалтанд албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.	- Албан хаагчдын мэдлэг, чадвар дээшилсэн байна. - 2018 он, сургалтын тоогоор,	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны Зөвлөл, Аймгийн ЗДТГ хамтран аймгийн төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл олгож чадавхижуулах зорилгоор “Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт”-ыг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Уг сургалтанд нийт 261 албан хаагч хамрагдав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу нийт 7 байгууллагын 8 албан хаагч 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр ёслол хүндэтгэлтэйгээр Төрийн	100

				<p>захиргааны албан хаагчийн тангарагаа өргөлөө. Тангараг өргөгчид: “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглаж, тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” хэмээн мэргэжил, мэдлэг нэгт хамт олныхоо өмнө тангараглалаа. Мөн 2018 онд аймгийн хэмжээнд 16 нас хүрч иргэний үнэмлэхээ гардан авч байгаа 161 хүүхэд байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн төлөөлөл болсон 15 сурагч Монгол Улсын иргэний андгай өргөж, иргэний үнэмлэхээ гардан авсан.</p> <p>Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөсөн албан хаагчдад болон Монгол Улсын иргэний андгай өргөсөн сурагчдад Лектор н.Жаргалсайхан “Дэлхий биднийг дуудаж байна” сэдвээр сонирхолтой лекц уншсан.</p>	
Албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах;					
4	Удирдлагын академийн зайн сургалтанд шинээр томилогдсон албан хаагчдыг хамруулах	- 2 албан хаагчийг сургалтанд хамруулна.	- Сургалтанд хамрагдсан албан хаагчид 100 хувь сертификаттай болсон байна.	Удирдлагын академийн “Төрийн албан хаагчийн манлайлах ур чадвар”, “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, эрх зүйн зохицуулалт” сэдэвт зайн сургалтад ТЗУХ-ийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, ХЭЗХ-ийн Гэрээний хяналт, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн, ХШҮДАХ-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ	70

				хариуцсан мэргэжилтнийг хамруулсан ба 1 мэргэжилтэн сертификат авсан.	
5	Бичиг хэрэг, архивын ажилтныг Архивын ерөнхий газарт мэргэшүүлэх сургалтанд хамруулах	- Сертификатын сургалтанд хамруулна. - Холбогдох зардлыг шийдвэрлэнэ.	- Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангагдсан байна.	Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтанд 2018 оны 05 дугаар сард хамрагдсан. Албан хэрэг хөтлөлтийн анхан шатны сертификаттай сургалтанд хамрагдаагүй.	0
6	Хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологи, олон нийттэй харилцах ажилтныг Эйбль программ хангамжийн сургалтанд хамруулах	- Холбогдох зардлыг шийдвэрлэн сургалтанд хамруулна.	- Эйбль программ хангамжийг нэвтрүүлсэн байна.	Эйбль программ хангамжийн сургалтыг 2018 оны 10 дугаар сарын 29, 30-ны өдөр зохион байгуулж, байгууллагын нийт 23 албан хаагчийг хамруулсан.	100
7	Төрийн жинхэнэ албан хаагчдыг Удирдлагын академи болон бусад байгууллагад суралцах боломжоор хангах	- Албан хаагчдыг шалгалтанд орох боломжоор хангана. - 1 болон түүнээс дээш албан хаагчид болзлыг хангаж, сургалтанд хамрагдсан байна.	- Тэнцсэн албан хаагчдыг суралцах боломжоор хангасан байна.	Удирдлагын академийн мэргэшүүлэх дипломын сургалтын элсэлтийн шалгалтад ХЭЗХ-ийн дарга, ХОХБТХ-ийн мэргэжилтэн орсон ба ХЭЗХ-ийн дарга суралцах эрх авсан. ХЭЗХ-ийн дарга нь 2018.10.30-наас хичээлдээ орсон ба байгууллагаас суралцах боломжоор ханган ажиллаж байна.	100
8	Эрхэлж буй ажил үүргийн дагуу мэргэжил дээшлүүлэх болон магистр, докторын зэрэг ахих сургалтад хамрагдах албан хаагчдад байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх;	- Албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, магистр, докторын сургалтанд суралцахад чөлөө олгох болон байгууллагын зүгээс суралцах нөхцөл боломжийг хангаж ажиллана.	- Ажилтан, албан хаагчдын эзэмшсэн мэргэжлийн дагуу мэдлэг, чадвар дээшилсэн байна. - Хариуцсан ажилдаа үр бүтээл гарган ажилласан байх.	Удирдлагын академийн магистрын зэрэг олгох ангид ХОХБТХ-ийн дарга элсэн орж, хичээл нь 2018.11.01-нд эхэлсэн. Байгууллагын зүгээс суралцах боломжоор ханган ажиллаж байна.	100
9	Албан хаагчдыг ажил үүргээ хэрэгжүүлэх, практик чадварыг сайжруулах зорилгоор ижил чиг үүргийн байгууллагуудын сайн туршлагыг судалж, суралцахад нь дэмжлэг	- Байгууллагын хамт олныг албан байгууллага болон бусад аймаг, орон нутгийн сайн туршлагыг судлан	- 2-оос доошгүй сайн туршлагыг нэвтрүүлсэн байх.	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын 25 албан хаагчийг 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Дархан-Уул аймгийн ЗДТГ-тай харилцан туршлага судлуулсан. - 2018 оны 10 дугаар сарын 22-	70

	үзүүлэх;	нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах		23-ны өдрүүдэд байгууллагын 12 албан хаагч Өмнөговь аймгийн ЗДТГ-тай харилцан туршлага судалсан. Туршлага судалсны үр дүнд албан хэрэг хөтлөлтийн Эйбль системийг нэвтрүүлж байна. Мөн ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэхээр судалж байна.	
Албан хаагчдыг Эрхэлж буй ажил үүргийн чиглэлийн дагуу гадаад улсад богино хугацааны сургалт, семинар, зөвлөгөөнд хамруулах, дэмжлэг үзүүлэх					
10	Засгийн газар, холбогдох яам, Тамгын газраас зохион байгуулж буй гадаад сургалт, уулзалт, зөвлөгөөнд холбогдох албан тушаалтан, албан хаагчдыг хамруулах	- Удирдамжид заагдсан арга хэмжээнд оролцох - Томилолт, замын зардал болон бусад холбогдох зардлыг шийдвэрлэх	- Холбогдох албан тушаалтныг бүрэн хамруулсан байх - Үр дүнд хүрсэн байх	Гадаад улсад туршлага судлах, уулзалт, зөвлөгөөнд оролцуулах, сургалтанд хамрагдах нөхцөл боломжоор хангаж ажилласны үр дүнд 6 албан хаагч гадаадад туршлага судалж, сургалт, зөвлөгөөнд хамрагдсан.	100
11	Аймаг, орон нутгийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд гадаад харилцааны асуудал хариуцсан албан хаагч болон бусад холбогдох албан хаагчдыг гадаад сургалт, уулзалт, зөвлөгөөнд оролцоход дэмжлэг үзүүлэх	- Удирдамжид заагдсан арга хэмжээнд оролцох - Томилолт, замын зардал болон бусад холбогдох зардлыг шийдвэрлэх - 2-оос доошгүй ажилтан, албан хаагчдыг холбогдох арга хэмжээнд хамруулах	- Холбогдох ажилтан, албан хаагчдыг хамруулсан байх - Мэдлэг, чадвар нэмэгдэж, хариуцсан ажилдаа нэвтрүүлж, үр дүнд хүрсэн байх.	Аймгийн ЗДТГ-аас Гадаад улсад туршлага судлах, уулзалт, зөвлөгөөнд оролцуулах, сургалтанд хамрагдах нөхцөл боломжоор хангаж ажилласны үр дүнд 6 албан хаагч гадаадад туршлага судалж, сургалт, зөвлөгөөнд хамрагдсан. Зүүн хойд Азийн засаг захиргааны холбоо (NEAR)-ны үйл ажиллагаанд тогтмол идэвхитэй оролцож аймгийн Засаг дарга БНХАУ-д, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Уранцэцэг Солонгос улсад, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод зохион байгуулагдах аравдугаар удаагийн “Хятад, Монгол, Оросын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны чуулга уулзалт”-нд аймгийн Засаг даргын орлогч, Хөрөнгө оруулалт, хөгжлийн	100

				бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга нар, Үр дүнг сайжруулах үйл ажиллагаа сэдэвт сургалт Солонгос улсад ХШҮДАХ-ийн дарга, Монголын Хөдөө аж ахуйн машин механизмын практик сургалтанд БНХАУ-д 1 сарын хугацаатай ХОХБТХ-ийн мэргэжилтэн тус тус хамрагдсан байна.	
Ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж, ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх					
12	Ажлын байранд ажилтан албан хаагчдын хөгжих боломжийг бүрдүүлж дотоод сургалтыг зохион байгуулах	- 14 хоног тутам ажлын байранд сургалтыг тогтмол зохион байгуулна.	- Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг 100 хувь хангана.	Ажлын байранд ажилтан албан хаагчдын хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулан ажиллаж байна. 2018 онд 11 сэдвээр дотоод сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 91 албан хаагч хамрагдсан байна.	100
13	Төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас сургалт авах	- Мэргэжлийн байгууллагаас 2-оос доошгүй сургалт авна.	- Нийт албан хаагчдыг хамруулсан байх - Албан хаагчдаас ёс зүйн зөрчил гаргаагүй байх - Цагдаагийн байгууллагад зөрчил бүртгэгдээгүй байх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны Зөвлөл, Аймгийн ЗДТГ хамтран аймгийн төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл олгож чадавхижуулах зорилгоор “Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт”-ыг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Уг сургалтанд нийт 261 албан хаагч хамрагдав. Мөн Хууль эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан мэргэжилтэн Г.Сумъяа 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр аймгийн ЗДТГ-ын нийт 25 албан хаагчид “Төрийн албан	100

				хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт зохион байгуулсан.	
14	Төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг, төрийн албаны үйл ажиллагааг сайжруулах, төрийн албан хаагчийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор уралдаан, тэмцээн зохион байгуулна.	- 2-оос доошгүй уралдаан, тэмцээн зохион байгуулна .	- Нийт албан хаагчдыг бүрэн хамруулсан байх - Үр дүнтэй байх	Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс “Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулахад чиглэсэн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэх хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, төрийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн шинэ санал, санаачилгыг дэмжиж түгээн дэлгэрүүлэх зорилготой илтгэлийн уралдааныг 2018 оны 10 сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Уралдаанд төрийн байгууллагын албан хаагчид идэвхитэй оролцож, Монголын мэтгэлцээний тэнхимийн сургагч багш Ч.Сайханаа, аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга М.Анхбаяр, аймгийн Шүүхийн тамгын хэлтсийн дарга Д.Сувдаа нар шүүн явууллаа. Илтгэлийн уралдаанд оролцогчид “Төрийн албаны шинэчлэлд албан хаагчийн үүрэг оролцоо”, “Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ажлын гүйцэтгэл иргэдийн сэтгэл ханамжид нөлөөлөх нь” сэдэв, агуулгын хүрээнд сонирхолтой, олон шинэ санал, санаачилга гаргасан илтгэлүүдийг тавьсан. Илтгэлийн уралдаанд өөрийн	100

				<p>илтгэх ур чадвар болон дэвшүүлсэн санаа, агуулгад нийцсэн байдал зэрэг илтгэлд тавих шалгуурыг хангаж бусдыгаа манлайлсан Боржигин өв музейн бүртгэл мэдээллийн санч Д.Өлзийбаяр Нэгдүгээр байр, Сүмбэр сумын 1-р сургуулийн багш П.Баярхүү Хоёрдугаар байр, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн О.Болор-Эрдэнэ Гуравдугаар байр тус тус эзэлж шагналаа гардан авлаа.</p> <p>Хуулийн байгууллагын албан хаагчдын бүтээлч сэтгэлгээг нэмэгдүүлэх, нийгмийн олон талт асуудалд оролцох тэдний оролцоо, нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх, манлайлах эрмэлзлэлийг төрүүлэх, гишүүдийн цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор аймгийн "Хуулийн байгууллагуудын дунд мэтгэлцээн"-ий тэмцээнийг 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Мэтгэлцээнийг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан ба тэмцээнд Шүүхийн Тамгын Газар, Цагдаагийн хэлтэс, Прокурорын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба-425 дугаар нээлттэй хорих анги тус тус оролцсон.</p>	
15	Төрийн үйлчилгээний ажилтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн сургалтыг зохион	- 2-оос доошгүй сургалт зохион байгуулсан байх	- Нийт албан хаагчдыг хамруулсан байх - Албан хаагчдаас ёс зүйн	Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран	100

байгуулах		зөрчил гаргаагүй байх - Цагдаагийн байгууллагад зөрчил бүртгэгдээгүй байх	<p>үйлчилгээний ажилчдын зөвлөгөөнийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд аймгийн төр болон хувийн хэвшлийн үйлчилгээний ажилтан, Үйлдвэрчний эвлэлийн хороодын дарга, удирдах ажилтнуудын төлөөллүүд нийт 50 ажилтан хамрагдсан. Зөвлөгөөнд “Зохистой хөдөлмөр ба харилцааны ур чадвар”, “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга ба Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны байр суурь”, “Үйлчилгээний ажилчдын харилцаа хандлага, ёс зүй”, “Үйлчилгээний газруудад мөрдөгдөх дүрэм журам, түүний хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” зэрэг сэдвүүдээр илтгэл тавигдаж, санал хэлэлцүүлэг явагдлаа.</p> <p>Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан мэргэжилтэн 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр байгууллагынхаа нийт 22 ажилтан, албан хаагчид Төрийн тухай хуулиар (шинэчилсэн найруулга) сургалт зохион байгуулсан.</p>	
Биелэлт				82.6

Төлөвлөгөөний биелэлт гаргасан: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Отгончимэг

Хянасан: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга:

М.Анхбаяр

